

Нар Ажиглагч: Хэрэглэх заавар



Нарны Бүтэн Хиртэлт

Даваа гараг, 2024 оны 4 сарын 8



TERMS AND CONDITIONS FOR USE OF ECLIPSE GLASSES

Please read these Instructions for Use carefully before using the Eclipse Glasses. Your purchase and use of the Eclipse Glasses constitutes your agreement to these Terms and Conditions. Failure to follow these Instructions for Use may result in serious personal injury, including permanent eye damage. If you do not understand these Instructions or cannot follow them diligently and completely, then you should not look at the Sun at any time, with or without the Eclipse Glasses.

The term “Eclipse Glasses” refers to the special cardboard-and-polymer optical products, marked “ISO 12312-2” and “SAFE FOR DIRECT SOLAR VIEWING”, manufactured by Rainbow Symphony of Reseda CA or American Paper Optics of Bartlett TN, and sold by Eclipse2024.org for the purpose of viewing the Sun during the solar eclipse of April 8, 2024, by or under the direct supervision of a person 18 years of age or above and in accordance with these Instructions for Use.

Observing the Sun directly, without the benefit of eye protection provided by the Eclipse Glasses, will likely result in serious personal injury, up to and including permanent eye damage and blindness. When these Instructions for Use are followed completely and precisely, the undamaged and unmodified Eclipse Glasses have been proven to be safe and effective in allowing direct, short-term viewing of the Sun. If these Instructions for Use are not followed, or if damaged or modified Eclipse Glasses are used, permanent eye injury could result.

You should never look directly at the Sun, with or without the aid of the Eclipse Glasses, if you have any temporary or permanent medical or other condition which either (1) prevents your use of the Eclipse Glasses according to these Instructions for Use, or (2) which predisposes you to an increased or special risk of incurring, worsening, or contributing to the effects of any optical condition, or other medical, health, or other condition, by looking or attempting to look at the Sun.

You should never attempt to perform any other activity (such as driving or walking) while using the Eclipse Glasses.

You agree that if you allow others to use the Eclipse Glasses, you will provide each such user with a copy of these Instructions for Use and will make sure such user reads and understands the Instructions for Use before using the Eclipse Glasses.

By using the Eclipse Glasses to view the Sun, you agree with the following:

- (a) you understand these Instructions for Use completely;
- (b) you understand and accept the risks associated with improper use of the Eclipse Glasses;
- (c) you accept full responsibility for, and assume all risks associated with, the act of viewing the Sun, with or without the use of the Eclipse Glasses; and
- (d) the Eclipse Glasses are fragile, and any damage or modification will render them immediately and permanently unusable for their intended purpose.

Release and Limitation of Liability

By way of purchasing and using the Eclipse Glasses, you are irrevocably releasing, indemnifying, and holding harmless the manufacturer and seller from any liability, loss, claim and expense (including attorney’s fees), including but not limited to bodily injury or other personal harm, which may result from using the Eclipse Glasses under any circumstances or conditions and irrespective of jurisdiction. Neither the manufacturer nor the seller will be responsible for any damages of any kind, irrespective of reasons, conditions or circumstances, including malfunctioning of the Eclipse Glasses. All risks associated with using the Eclipse Glasses rest solely and entirely with the user, irrespective of whether the Eclipse Glasses are used by the original purchaser or any third party. You fully understand and assume the risks in using the Eclipse Glasses. You confirm that you have read this release of liability and fully understand its terms and that you have given up substantial rights by purchasing and using the Eclipse Glasses.

THE MANUFACTURER AND SELLER OF THE ECLIPSE GLASSES MAKE NO WARRANTY OF ANY KIND, EXPRESSED OR IMPLIED, WITH RESPECT TO THE ECLIPSE GLASSES, INCLUDING BUT NOT LIMITED TO THE IMPLIED WARRANTIES OF MERCHANTABILITY, FITNESS FOR A PARTICULAR PURPOSE, AND NON-INFRINGEMENT. NEITHER THE MANUFACTURER NOR THE SELLER SHALL BE LIABLE FOR ANY OTHER DAMAGES, INCLUDING BUT NOT LIMITED TO DIRECT, INDIRECT, INCIDENTAL, SPECIAL, CONSEQUENTIAL, OR EXEMPLARY DAMAGES, WHETHER IN AN ACTION IN CONTRACT OR TORT (INCLUDING NEGLIGENCE AND STRICT LIABILITY), SUCH AS, BUT NOT LIMITED TO, LOSS OF ANTICIPATED PROFITS OR BENEFITS RESULTING FROM, OR ARISING OUT OF, OR IN CONNECTION WITH THE USE OR FURNISHING OF THE ECLIPSE GLASSES OR THE PERFORMANCE, USE OR INABILITY TO USE THE SAME, EVEN IF THE MANUFACTURER OR SELLER HAS BEEN ADVISED OF THE POSSIBILITY OF SUCH DAMAGES. IN NO EVENT WILL THE MANUFACTURER’S OR SELLER’S TOTAL LIABILITY EXCEED THE PRICE PAID FOR THE PRODUCT.

Note Regarding Translations

[Translations](#) of these Instructions for Use into various languages are provided “AS-IS” and solely for the convenience of the reader. Eclipse2024.org has made reasonable efforts to ensure the accuracy of the Translations; however, in the event of any perceived discrepancy in meaning or interpretation between the English version and any Translation, the English version will prevail. You should not act in reliance on anything contained in any Translation of these Instructions for Use, but should refer to the official English version.


НАРНЫ БҮТЭН ХИРТЭЛТ – 2024 оны 4-р сарын 8

Хойд Америкт тавтай морилно уу!

Нарны бүтэн хиртэлтийг үзэхийн тулд манай оронд зочлохоор шийдсэн тань бидэнд нэр төрийн хэрэг бөгөөд хүн бүр энэхүү сүр жавхлантай үзэгдлийг аюул осолгүй хараасай хэмээн бид хүсч байна!

Бид таны ая тухыг хангах үүднээс энэхүү зааварчилгааг Монгол хэлээр хүргэж байна. Эдгээр заавар, зөвлөмж болон мэдэгдлүүд (“Заавар”)-ийн Англи хувилбар нь нарыг шууд харахад зориулагдсан Нар Ажиглагчийг зүй зохистой, зөв хэрэглэх мэдээллүүд ба удирдамжийн бүрэн дүүрэн эх сурвалж юм. Зааврууд нь <https://tinyurl.com/2024Instructions> холбоост байгаа ба та Нар Ажиглагчийг хэрэглэхийн тулд тэдгээрийг уншиж ойлгон, дагаж мөрдөх учиртай. Зааврыг даган мөрдөхгүй байх нь хувийн ноцтой осол гэмтэлд хүргэж болзошгүй.

Одон орончид 2024 оны 4 сарын 8-нд болох нар хиртэлтийг “бүтэн хиртэлт” гэж нэрлэж байгаа ба бүрэн хиртэлтийг харахын тулд та Хойд Америкийг хөндлөн туулсан маш нарийн зурвас газар (“Бүтэн Хиртэлтийн Зам” хэмээн нэрлэгддэг)-т байх ёстой. Хэрвээ та энэ замд байгаа л биш бол, зөвхөн хагас хиртэлтийг л харах болно! Тиймээс та бүтэн хиртэлтийн зам дагуу байгаа эсэх нь маш чухал бөгөөд хэрэглэх аргыг удахгүй тайлбарлах болно.



Бүтэн Хиртэлтийн Зам

ТОВЧ ГАРЫН АВЛАГА

ДЭЛГЭРЭНГҮЙ ЗААВАР

Энэ баримт бичиг хэрэглэгдэж буй “Нар Ажиглагч” хэмээх нэр томъёо нь энэхүү баримт бичиг дотор болоод эхний хуудсанд байгаа хариуцлагаас татгалзах мэдэгдэлд дурдагдсан “Eclipse Glasses”-ийг төлөөлж байгаа гэж ойлгож болно.

Та нарыг харах зорилгоор Нар Ажиглагчийг ашиглах хууль ёсны гэрээг байгуулна. Та Нар Ажиглагчийг ашиглан ямар ч үед нарыг харахын тулд, энэхүү зааварт агуулагдаж буй бүх заавар, заалтуудыг нарийн нягт, бүрэн дагах ёстой. Хэрэв та зааврыг ойлгохгүй бол, эсвэл тэдгээрийг шударгаар даган мөрдөж чадахгүй бол, эсвэл тэдгээр нөхцлүүдийг зөвшөөрөхгүй байвал, ямар нэгэн арга ашиглан хэдийд ч нарыг харахаар оролдохгүй байхыг танд зааж, зөвлөж байна.

НАР АЖИГЛАГЧИЙН ТОВЧ ГАРЫН АВЛАГА

Энэхүү Гарын Авлагыг [монгол хэл дээрх дэлгэрэнгүй цогц Заавраас](#) хураангуйлсан ба Нар Ажиглагчийг ашиглан хиртэлтийг харахын тулд та бүхэлд нь уншиж, ойлгож, мөрдөх ёстой.









- 1) Өөрийн байгаа байршилд нар хиртэлт бүтэн болох эсэхийг, түүнчлэн уг байршилд хагас болон (хэрвээ хамаарах бол) бүтэн хиртэлт болох ойролцоо цаг хугацааг харахыг хүсвэл өөрийн байршлаа eclipse2024.org/find-times-ээс хайна уу.
- 2) Бүтэн хиртэлт нь туйлын сонирхол татам үзэгдэл хэдий ч та “бүтэн хиртэлтийн зам” буюу – ердөө хоёр зуу орчим километрийн өргөнтэй зурвас газарт л бүтэн хиртэлтийг мэдэрч чадна. Хэрвээ бүтэн хиртэлт таны харахаар төлөвлөсөн газраас үзэгдэхгүй бол, бүтэн хиртэлтийн зам руу шилжин очихыг бид хатуу зөвлөж байна!
- 3) Нар Ажиглагчийг ашиглан хиртэлтийг харахын тулд, Нар Ажиглагчийн хамгаалалтын шилийг нүдэн дээрээ шууд аваачна уу, ингэснээр таны нүд нарыг шууд харахаас бүрэн хамгаалагдах болно.
- 4) Нар Ажиглагчийг ашиглан нарыг хэзээ харах вэ:
 - a. Хэрвээ хиртэлт таны байгаа байршилд **БҮТЭН БУС** байх бол, байнга Нар Ажиглагчаар харна уу. **ХЭРВЭЭ ТА ЗҮЙ ЗОХИСТОЙ ХАМГААЛАЛТГҮЙГЭЭР НАРЫГ ХАРВАЛ НҮДЭНДЭЭ УДААН ХУГАЦААНЫ ГЭМТЭЛ АВАХ ЭРСДЭЛТЭЙ!**
 - b. Хэрвээ хиртэлт таны байршилд **БҮТЭН БАЙХ** бол, Нарны тойргийн ямар нэг хурц тод хэсэг – өчүүхэн төдий ч – харагдаж байх тохиолдолд та Нар Ажиглагчаар Нарыг харах ёстой. **ТА ЭНЭ ЗААВРЫГ ДАГАЖ МӨРДӨХГҮЙ БОЛ НҮДЭНДЭЭ НОЦТОЙ ГЭМТЭЛ АВАХ ЭРСДЭЛТЭЙ!**
 - i. Гэхдээ, **ЗӨВХӨН бүтэн хиртсэн богинохон хугацаанд**, нарны тойргийн хурц тод цацраг огт харагдахгүй болох үед та, Нар Ажиглагчийг хэрэглэлгүйгээр бүтэн хиртэлтийг шууд харах хэрэгтэй.
 - ii. Үнэн хэрэгтээ бүтэн хиртсэн үед нь Нар Ажиглагчийг ашиглан нарыг харахаар оролдовол, танд юу ч харагдахгүй!
 - iii. Бүтэн хиртэлт дуусч, Нарны тойргийн хурц тод хэсэг харагдаж эхлэнгүүт та буцаад Нар Ажиглагчаа ашиглах ЁСТОЙ.
- 5) Өөрөөр хэлбэл,

**НАРНЫ ХУРЦ ТОЙРГИЙН АЛЬ НЭГ ХЭСЭГ ХАРАГДАЖ БАЙХ ҮЕД ТА,
НАР АЖИГЛАГЧИЙГ АШИГЛАН НАРЫГ ХАРАХ ЁСТОЙ!**

НАР АЖИГЛАГЧИЙГ АШИГЛАХ ДЭЛГЭРЭНГҮЙ ЗААВАР

Юуны өмнө, таны мэдэх хэрэгтэй зарим нэг нэр томъёог тайлбарлая!

Хиртэлт бүрт болон дэлхий дээрх байршил бүрт, тодорхой чухал үзэгдлүүдэд өгөгдсөн нэрс байдаг. Тэдгээр нь:


Үзэгдлийн Нэр	Үзэгдлийн Тайлбар	Харагдах байдал (Бүтэн Хиртэлтийн хувьд)	Харагдах байдал (Хагас Хиртэлтийн хувьд)
C1	Хагас хиртэлтийн эхлэл		
C2	Бүтэн хиртэлтийн эхлэл		**Тохихгүй!**
Хиртэлтийн-Оргил үе	Хиртэлтийн дунд-үе		
C3	Бүтэн хиртэлтийн төгсгөл		**Тохихгүй!**
C4	Хагас хиртэлтийн төгсгөл		

1) НАР АЖИГЛАГЧИЙГ АШИГЛАХ ЕРӨНХИЙ ЗААВАР



- 1) [хэрвээ хамаатай бол] Нар Ажиглагчийг сав баглаанаас нь болгоомжтой гаргана уу.
- 2) Хэрэглээгүй үедээ Нар Ажиглагчийг аюулгүй байлгана уу.
- 3) Хэрэглэх бүртээ Нар Ажиглагчийг шалгана уу; хэрэв хамгаалагч хальс нь ямар нэг байдлаар гэмтсэн эсвэл үрчийж хунирсан байвал, Нар Ажиглагчийг хэсэглэн хувааж устгаад [шинээр сольж аваарай](#).
- 4) Хэрвээ хамгаалагч хальс нь ямар нэг байдлаар гэмтсэн бол, Нар Ажиглагчаар Нарыг ямар ч үед харж болохгүй.
- 5) Хамгаалагч хальсны материалыг Нар Ажиглагчаас салгаж авч болохгүй ба салгасан хамгаалагч хальсаар Нарыг ямар нэг байдлаар харахыг хориглоно.
- 6) Нар Ажиглагчийн зөв-үгсрагдсан, гэмтэлгүй хамгаалагч шил нь үзэгдэх гэрлийн аюултай түвшнийг, түүнчлэн хортой хэт ягаан туяа болон бусад нарны туяаг найдвартай хаах болно. Тиймээс, эдгээр зааврууд дээрх заалтуудын дагуу Нар Ажиглагчийг ашиглан Нарыг харах нь бүрэн аюулгүй юм. Хиртэлтийн үеэр Нар харахыг илүү аюултай эсвэл бага аюултай болгодог ямар нэгэн онцгой “хиртэлтийн туяа” гэж байдаггүй.
- 7) **Нарны хурц тойргийн АЛЬ НЭГ хэсэг харагдаж байх үед Нарыг аюулгүйгээр харахын тулд, та энд тодорхойлсон байдлаар Нар Ажиглагчийг хэрэглэх ёстой. Таны аливаа эх сурвалжаас авсан хиртэлт болох цаг (тухайлбал, дээр дүрсэлсэн “С2” ба “С3”) хэдийд байхаас үл хамааран энэ бүгд нь үнэн.**
- 8) Нар Ажиглагчийг ямар нэг телескоп, дуран, зургийн аппарат, линз, толь буюу өөр бусад оптик хэрэгсэл, төхөөрөмж ба гэрэл дамжуулж, тусгаж болох объектой (“Оптик Төхөөрөмж”) хамт хэрэглэж болохгүйг анхаарна уу.
- 9) Тиймэрхүү Оптик Төхөөрөмжийг Нар руу хэзээ ч чиглүүлж болохгүй бөгөөд Нар руу чиглүүлсэн, эсвэл ямар нэг байдлаар Нарны гэрлийг цуглуулж, төвлөрүүлж, дахин чиглүүлж буй Оптик Төхөөрөмжийг ашиглан Нарны дүрсийг хэзээ ч шууд харж болохгүй.
- 10) Нар Ажиглагчийг, амьтанд, эсвэл түр зуурын согогтой, уншиж, ойлгож, Нар Ажиглагчийн аюулгүй ашиглах болзол шаардлагыг даган биелүүлж чадахгүй буюу өөрсдийн үйлдлийн хариуцлагыг хууль ёсоор хүлээж чадахгүй хүмүүст ашиглуулахыг бүү зөвшөөрнө үү.
- 11) Нар Ажиглагчийг хэрэглэхийн тулд:


Нар Ажиглагчийг Нар болон нүднийхээ хооронд ямар ч үед бүрэн байлгаж, элдэв гэмтэлгүй хамгаалагч шилээр Нар руу харна уу. Нар Ажиглагч нь картонон нүдний шил шиг хэлбэртэй тохиолдолд, та уламжлалт нүдний шил зүүдгийн адилаар Нар Ажиглагчийн картоныг нугалж зүүнэ. Нар Ажиглагчийн гэмтэлгүй хамгаалагч шилээр харж байгаа л биш бол, та бүтэн бус хиртэлттэй байгаа (хэрвээ таны ажиглалтын байршилд хамаатай бол, доорх хүснэгтийн С2 ба С3-ын хоорондох хугацаанд байх үе) Нарыг хэзээ ч бүү шууд хараарай.
- 12) Нар Ажиглагчийн раманд анх суурилуулсан хамгаалалтын шилнээс өөр ямар нэг материал буюу объектыг, Нарыг харах нүдний хамгаалалт болгон бүү хэрэглээрэй.
- 13) Танд эдгээр заавруудын талаар ямар нэг асуулт байвал, <https://tinyurl.com/glasses-questions> холбоосоор орж Eclipse2024.org-той холбогдоно уу.



2) ӨӨРИЙН БАЙРШИЛ ДАХЬ ХИРТЭЛТИЙН ҮЗЭГДЛҮҮДИЙН ТОДОРХОЙ ЦАГИЙГ МЭДЭХ

Таны байршлын талаар eclipse2024.org/find-times дээр өгөгдсөн мэдээлэл дээр үндэслэн, дараах мэдэгдлийг гүйцэтгэнэ үү:

Миний байршилд, хиртэлт нь:



(нэгийг дугуйл)

Хэрвээ хиртэлт нь таны байршилд

БҮТЭН байх бол

**“ХИРТЭЛТ, МИНИЙ
БАЙРШИЛД**

БҮТЭН”

[гэсэн доорх хэсэг](#)

дэх зааврыг дага:

Хэрвээ хиртэлт нь таны байршилд

БҮТЭН БУС байх бол

**“ХИРТЭЛТ, МИНИЙ
БАЙРШИЛД**

БҮТЭН БУС”















[гэсэн доорх хэсэг](#)

дэх зааврыг дага:

**** ХИРТЭЛТ, МИНИЙ БАЙРШИЛД БҮТЭН ****

Та бүтэн хиртэлтийн замд байснаар ховор, гайхалтай үзэгдлийг мэдрэх болно! Таны хувьд байгаа байршилдаа хэзээ бүтэн хиртэлт болохыг тодорхойлох нь маш чухал юм. Доор тэмдэглэсэн цагуудыг авч үзсэнээр, түүнчлэн бүтэн хиртэлтийн үеэр Нарны тойргийн хурц тод хэсэг харагдахгүй учраас та үүнийг тодорхойлж чадах юм.

- 1) Таны байршлын талаарх eclipse2024.org/find-times дээрх мэдээлэлд үндэслэн, доор дурдсан хиртэлтийн үзэгдлүүд тохиох ойролцоо цагуудыг бичиж авна уу (цагуудыг өөрийн байгаа [цагийн бүстэй](#) [тохируулахаа](#) бүү мартаарай!):

C1-ийн өмнө	* Хиртэлт байхгүй *				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ
C1	Хагас хиртэлт эхэлнэ:				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ
C2	Бүтэн хиртэлт эхэлнэ:				C2-ийн дараа , та энгийн нүдээр ажиглаж болно
Хиртэлтийн-Оргил үе	Тохионо:				Та энгийн нүдээр ажиглаж болно!
C3	Бүтэн хиртэлт дуусна:				Та, Нар Ажиглагчийг дахин хэрэглэх ЁСТОЙ
C4	Хагас хиртэлт дуусна:				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ
C4-ийн дараа	* Хиртэлт байхгүй*				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ

- 2) Хэдийгээр та бүтэн хиртэлтийн замд байрлаж байгаа ч, C2-ын өмнө болон C3-ын дараа, хиртэлт бүтэн бус байх үед Нарыг харахдаа, Нар Ажиглагчийг бас л хэрэглэх **ЁСТОЙ**.

- 3) Та ЗӨВХӨН дараах тохиолдолд Нарыг энгийн нүдээр (Нар Ажиглагч хэрэглэлгүйгээр) шууд ажиглаж болно:
- Хэрвээ хиртэлт таны байршилд бүтэн тохиох бол (та “замд нь” байх үед)
 - бүтэн хиртэлтийн хугацааны түршид (ойролцоогоор, таны дээр тэмдэглэсэн C2 -оос C3 хүртэлх хугацааны түршид)
 - Нарны хурц тойргийг Сар БҮРЭН халхалсан тохиолдолд.**

Бүтэн хиртэлт тохиох бодит цаг нь таны яг хаана байгаагаас ихэд хамаарах учир та ойролцоо цагуудийг урьдчилан тодорхойлж, тэмдэглэж авах ёстой. Таны дээр тэмдэглэсэн цагууд нь ойролцоо цагууд юм!

- 4) Дахин хэлэхэд, дээрх жагсаалтанд тэмдэглэсэн эсвэл аливаа гадны эх сурвалжаас цуглуулсан аль ч цагаас үл хамааран, **та Нарны хурц тойргийн ЯМАР НЭГ ХЭСЭГ нүдэнд харагдахуйц болох БОЛГОНД Нар Ажиглагчийг ашиглан Нарыг харах ёстойг санаарай.**
- 5) Эдгээр заавруудыг ойлгоход дөхөм болгох үүднээс нэмэлт график тайлбаруудыг хавсаргасан болно.

Та дараах мэдэгдлүүдийг уншиж, ойлгож, даган мөрдөх ёстой:











НАР АЖИГЛАГЧИЙГ АЮУЛГҮЙ АШИГЛАХЫН ТУЛД, ТҮҮНИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ТУХАЙ БҮХ ЗААВРУУДЫГ ДАГАХ ЁСТОЙ.

ХЭРВЭЭ НАРНЫ ХУРЦ ТОЙРГИЙН АЛЬ НЭГ ХЭСЭГ ХАРАГДАЖ БАЙВАЛ, НАР АЖИГЛАГЧИЙГ АШИГЛАН НАРЫГ ХАРАХ ЁСТОЙ.

**** ХИРТЭЛТ, МИНИЙ БАЙРШИЛД БҮТЭН БУС ****

Та бүтэн хиртэлтийн замд байхгүй байснаар бүтэн хиртэлтийн сайхныг мэдэрч чадахгүй гэсэн үг. (Энэхүү гайхалтай мэдрэмжийг хуваалцахын тулд бүтэн хиртэлтийн замд очихыг бид танд ихээхэн зөвлөж байна!)

- 1) Таны байршлын талаарх eclipse2024.org/find-times дээрх мэдээлэлд үндэслэн, доор дурдсан хиртэлтийн үзэгдлүүд тохиох ойролцоо цагуудийг бичиж авна уу (цагуудыг өөрийн байгаа [цагийн бүстэй тохируулахаа](#) бүү мартаарай!):

C1-ийн өмнө	* Хиртэлт байхгүй *				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ
C1	Хагас хиртэлт эхэлнэ:				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ
Хиртэлтийн - Оргил үе	Тохионо:				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ
C4	Хагас хиртэлт дуусна:				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ
C4-ийн дараа	* Хиртэлт байхгүй *				Та, Нар Ажиглагчийг хэрэглэх ЁСТОЙ



(Хиртэлт таны байршилд бүтэн бус байх учраас C2, C3 цаг байхгүйг анхаарна уу!)

- 2) Таны байгаа газарт хиртэлт бүтэн бус байх учраас Нарыг ажиглахдаа та, Нар Ажиглагчийг **БАЙНГА** хэрэглэх ёстой. Дахин хэлэхэд, бид таныг бүтэн хиртэлтийн зам руу очихыг зөвлөж байна. Хагас хиртэлтийг аюул осолгүй ажиглах зорилгоор Нар Ажиглагчийг биедээ заавал авч авна уу!
- 3) Эдгээр заавруудыг ойлгоход дөхөм болгох үүднээс нэмэлт график тайлбаруудыг хавсаргасан болно.

Та дараах мэдэгдлүүдийг уншиж, ойлгож, даган мөрдөх ёстой:

НАР АЖИГЛАГЧИЙГ АЮУЛГҮЙ АШИГЛАХЫН ТУЛД, ТҮҮНИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ТУХАЙ **БҮХ ЗААВРУУДЫГ ДАГАХ ЁСТОЙ.**

НАРЫГ ХАРАХ ҮЕДЭЭ **ҮРГЭЛЖ НАР АЖИГЛАГЧИЙГ АШИГЛАХ ЁСТОЙ.**



PDF

Монгол хэл

GRAN ECLIPSE NORTEAMERICANO
GRANDE ÉCLIPSE NORD - AMÉRICAINÉ
GREAT NORTH AMERICAN ECLIPSE

